



ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ-2019

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН ДЭВТЭР



САНАМЖ, ЗӨВЛӨГӨӨ

1. Шалгалт **80 минут** үргэлжилнэ.
2. Хариултын хуудсыг зохих зааврын дагуу анхааралтай бөглөөрэй.
3. Хариултын хуудсан дээрх **“ХЯНАЛТЫН ХЭСЭГ”**-т ямар нэгэн тэмдэглэгээ хийхгүй байхыг анхаарна уу.
4. Хариултын хуудсан дээр зөв хариултад харгалзах (A) дүрсийг будаж (●) тэмдэглээрэй. Үүнээс өөрөөр тэмдэглэсэн, эсвэл давхар сонголт хийсэн тохиолдолд таны хариулт хүчингүйд тооцогдох болно.
5. Шалгалтын хугацаа дуусаж, хонх дуугарсны дараа хянагч багшийн тараах **“БАГАНАН КОД”**-ыг зураасны дагуу 2 хуваагаад 1 хувийг хариултын хуудасны **“Баганан код наах хэсэг”**-т, нөгөөг гэрээний хуудасны **“Баганан код наах хэсэг”**-т сумны дагуу наагаарай.
6. Шалгалтын материалыг БҮТ-д төвлөрүүлэн татаж, хадгална.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж:

1. Эхийг анхааралтай уншиж ойлгоод, даалгаврыг гүйцэтгээрэй.
2. Асуулт даалгавар бүрийг дуустал уншиж ойлгоорой.
3. 1-13 сорилыг эхийн утга санаатай холбож ажиллаарай.
4. Сонгож авсан үг, өгүүлбэрийг эхийн утга санаатай холбож ажиглаарай.
(Даалгавар бүр 2 оноотой)

ХАТАН ЭХИЙН ЗАРЛИГ

Шөнө дундаас хойхно цаг. Өүлэн эх ахлах хэвтүүлийг дуудан ирүүлээд:

“Тэмүүжин, Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудыг үтэр цуглуул...” гэж зарлиг айлдахад : Жа ... гээд эргэх гэснээ зогтусаж, “Ахайтан! Их эзнийг дээшлүүлэх гэж үү?” гэвэл өтгөн буурал гээгээ задалж суусан хатан ээж: “Тийм ээ! Тэр улсын хаан боловч миний үр учир үгийг дагах ёстой” гэв.

Хатан эхийн зарлигийг сонссон хөвгүүд, бэр, жанжин, хүлэг баатрууд тунгалаг тэнгэрт одод анивчиж, мичид шингэх мөчид эхэд бараалхах ёс жаягаар хувцаслан цуглав.

Толгой гудгар, царай урвагар Өүлэн ээж, зөөлөн зөөлөн алхалсаар ирж түр чимээгүй зогссоноо: “Хамаг Монголын Хаант улсын нэгэн эрхэм чухаг иргэн хорвоогоос халилаа. Иймийн учир, эрчүүл цагаан бөс зүүж, эмс бүсгүйчүүл гээгээ задалцгаа!” гэж зарлиг буулгаад: “Эзэн дээдсийн төлөөнөө ёсч шударга, цэгц үнэн журмыг сахихын үлгэрийг үзүүлсэн энэ иргэнийг Хамаг Монголын хаад, ноёд, харц ард хэн боловч мартаж ёсгүй...” гэхэд хамаг эрчүүл, зардсын барьсан цуулмал цагаан бөсийг малгайдаа зүүж, бүсгүйчүүл үсээ задлан унжуулав.

Өүлэн эх баруун ханцуйг үл ялиг хөдөлгөн, цэнхэр пансан алчуур гаргаж, хацар дагасан сувдан нулимсаа арчаад:

“Хаан Тэмүүжин, чи хагацлын үг айлдах уу?” гэв.

Хаантан эхийн зүг мэхэсхийн хүндэтгээд: “Эрэг шороо нурж, энхэл донхол үүсдэг бол иргэн хүн хальж, элэг зүрх эмтрэв. Хоёр сэтгэлт эр хүнийг эр бус эм хэмээлтэй, нэгэн сэтгэлт эмийг, эм бус эр хэмээлтэй гэсэн үг байдаг. Хаан, харц биднээсээ хагацан одсон Хуагчин эмгэн таныгаа баатрын ёсоор хүндлэх учиртай. Та, хаан эцэг Есүхэйн үеэс хатан ээжид минь үнэнч зүтгэж, хайртай Бөртэ хатныг минь бүхээгт тэргэнд нуун, бие сэтгэлээрээ хамгаалж явсан билээ. Хуагчин та, тэр нэгэн цөвүүн өдөр довтлон айсуу дайсныг солонго мэт сонсож, үен мэт үзэж, хатан эхэд минь хэлж, биднийг сэрээгээгүй сэн бол бөөс мэт биес минь Гурван мэргэдийн сумны зэв, сэлэмний ирийг мялаагаад дуусах байсан биш үү! Таны ачаар амьд гарсан бид өсөж өндийж, өрх гэрээ толгойлж, улс үндсээ аварч, өштөнөө өвдөглөж, атаатнаа атгаж, өдий зэрэгт хүрэв. Хаан хэдий хүчтэй ч харцын хүчинд түшьюү гэсэн мэргэн үг буй. Иймийн тул, эмгэн зарц таныгаа бид, түүхэндээ бичиж, түмэндээ сонордуулж явах болно” гэж айлдаад, хойшоо гурав алхахад эмгэний цонхигор нүүрийг гивлүүрээр бүтээв.

Бөөр алаг үхэрт хөллөсөн бүхээгт тэрэг Бунхат уулын зүг хөдөлж, холдон холдсоор үүрийн харанхуйд уусан одлоо.

М. Гүрсэд

1. “Эрчүүл цагаан бөс зүүж, эмс бүсгүйчүүл гээгээ задалцгаа!” гэж Өэлүн эх хэлсний учир юу вэ?
 - A. Эх хатан, хаан хоёрын зөрчил маргаанд домын арга хэрэглэж байсан учраас
 - B. Хаант улсын чухаг иргэн хорвоогоос хальсан тул гашуудан хүндэтгэх учраас
 - C. Гурван мэргэд дайран довтлох тул хүн бүр сэрэмж алдахгүй болгох учраас
 - D. Эрчүүл цагаан бөс зүүж, эмс бүсгүйчүүл гээгээ задлах нь шөнө дундын ёс учраас
 - E. Шөнө дундаас хойхно ахлах хэвтүүлүүд ямар нэгэн зүйлээс сэрэмж авсан учраас













2. Эхэд өгүүлснээр “мичид шингэх мөч” гэдэг нь аль цаг хугацааг илэрхийлж байна вэ?
- Хуагчин эмгэн тэртээ цагийн нэг шөнө довтлон ирж буй дайсны чимээг сонссон мөч
 - Хамаг Монголын Хаант улсад эрхэм үүрэг гүйцэтгэсэн Хуагчин эмгэний амьсгал хураасан үе
 - Хөвгүүд, бэр, жанжин, хүлэг баатрууд Өэлүн эхийн хэлсэн ёс жаягийг дагаж ирсэн хугацаа
 - Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудын байнгын ёслол үйлддэг хугацаа
 - Хуагчин эмгэний цогцсыг хөдөөлүүлэхээр авч яваа хугацаа
3. Хүндэтгэлийн үгийн утгыг зөв харгалзуулсан хэсгийг олоорой.
- | | |
|----------------|----------------------|
| 1. дээшлүүлэх | a.ярих, хэлэх |
| 2. сонордуулах | b.сэрээх, босгох |
| 3. айлдах | c.дуулгах, сонсгох |
| 4. халих | d.үхэх, амьгүй болох |
- A. 1c,2d,3b,4a B. 1a,2b,3c,4d C. 1b,2a,3c,4d D. 1b,2c,3a,4d E. 1d,2b,3a,4c
4. Эхийг сэдвийг сонгоорой.
- Хатан эхийн зарлигийг хөвгүүд, бэр, жанжин, хүлэг баатрууд дагасан тухай
 - Цэгц шударга, үнэнч зүтгэсэн хүнийг эрхэмлэн хүндэтгэж буй тухай
 - Бөртэ хатныг минь бүхээгт тэргэнд нуун, хамгаалж явсан тухай
 - Чингис хаан Хуагчин эмгэнд зориулан үг хэлж буй тухай
 - Эх хүнийг төрт ёсны дагуу хүндэтгэн хайрлаж хамгаалах тухай
5. Эхийн гол санааг илэрхийлэх хэлцийг сонгоорой.
- Хэлүүлж явах нэр, хэвтэж хоцрох яс
 - Төрийн нуруу төвшин бол түмний нуруу амгалан
 - Эвдрэх төрийн ноён байснаас энх төрийн боол байсан нь дээр
 - Шулуун явдлын гэгээн нь, шударга төрийн хүндлэл нь
 - Хаан гэгч улсдаа эзэн, харуул гэгч ордондоо эзэн
6. Эхийн үйл явдал өрнөж эхлэх шалтгаан юу вэ?
- Хойшоо гурав алхахад эмгэний цонхигор нүүрийг гивлүүрээр бүтээв.
 - “Тэмүүжин, Бөртэ тэргүүтэй хөвгүүд, бэрс, шадар, баатруудыг үтэр цуглуул...” гэж зарлиг айлдав.
 - Хоёр сэтгэлт эр хүнийг, эр бус эм хэмээлтэй, нэгэн сэтгэлт эмийг, эм бус эр хэмээлтэй гэсэн үг байдаг.
 - Хамаг эрчүүл, зардсын барьсан цуулмал цагаан бөсийг малгайдаа зүүж, бүсгүйчүүл үсээ задлан унжуулав.
 - Бөөр алаг үхэрт хөллөсөн бүхээгт тэрэг Бунхат уулын зүг хөдөлж, холдон холдсоор үүрийн харанхуйд уусан одлоо.
7. “**Иймийн тул**, эмгэн зарц таныгаа бид, түүхэндээ бичиж, түмэндээ сонордуулж явах болно” онцолсон холбох үгийг ямар үүргээр хэрэглэсэн байна вэ?
- Үйлийн орны адил төсийг тогтоох
 - Мэдээллийг хооронд нь жиших харьцуулах
 - Өмнөх мэдээллээс дараагийн мэдээллийг ялган онцлох
 - Өмнөх мэдээллүүдийг ерөнхийлөн дүгнэх
 - Мэдлээлэлд хоорондын шалтгаан-үрийг тодруулах
8. Их хаан, Хуагчин эмгэний үнэнч шударга зүтгэлийг хэрхэн үнэлж дүгнэсэн бэ?
- Эрэг шороо нурж, энхэл донхол үүсдэг бол иргэн хүн хальж, элэг зүрх эмтрэв.
 - Энэ иргэнийг хамаг монголын хаад, ноёд, харц ард хэн боловч мартаж ёсгүй...
 - Хаан, харц биднээсээ хагацан одсон Хуагчин эмгэн таныгаа хүндлэх учиртай.
 - Хоёр сэтгэлт эр хүнийг, эр бус эм хэмээлтэй, нэгэн сэтгэлт эмийг, эм бус эр хэмээлтэй гэсэн үг байдаг.
 - Таны ачаар амьд гарсан бид өсөж өндийж, өрх гэрээ толгойлж, улс үндсээ аварч өстнөө өвдөглөж, атаатнаа атгаж өдий зэрэгт хүрэв.








9. “Бөөр алаг үхэрт хөллөсөн бүхээгт тэрэг Бунхат уулын зүг хөдөлж, холдон холдсоор үүрийн харанхуйд уусан одлоо” гэсэн хэсгээс үйл явдлын хувирал өөрчлөлтийг дүрслэхэд чухал үүрэгтэй үг хэллэгийг олоорой.
- хөллөх, хөдлөх, холдох, уусан одох
 - үхэрт хөллөсөн, бүхээгт тэрэг хөдлөх
 - бөөр алаг, үүрийн харанхуй
 - бүхээгт тэрэг, харанхуйд уусах
 - Бунхат уулын зүг, холдон холдох
10. “Тэр нэгэн цөвүүн өдөр довтлон айсуу дайсныг **солонго мэт** сонсож, **үен мэт** үзэв” гэсэн өгүүлбэрийн онцолсон дүрслэлийг олоорой.
- егөөдөл
 - амьдчилал
 - адилтгал
 - багасгал
 - бэлгэдэл
11. “Хуагчин эмгэн Бөртэ хатныг минь бүхээгт тэргэнд нуун **бие сэтгэлээрээ хамгаалж явсан билээ**” өгүүлбэрийн онцолсон үгийг хэлцээр солин найруулбал аль нь *тохирохгүй* вэ?
- зүрх гаргах
 - хоёргүй сэтгэлээр
 - амь тавин зүтгэх
 - хар толгойгоо бодох
 - амиа хайрлахгүй
12. Хуагчины “Эрхэм чухаг иргэн” болох шинжийг тодруулах үүргээр орсон бүлэг үгс аль вэ?
- Өэлүн эх, Тэмүүжин, Бөртэ, хөвгүүд, бэрс, шадар баатрууд, ахлах хэвтүүл, зардас, хаад ноёд, харц, хамаг эрчүүл
 - ёсч шударга, цэгц үнэнч, нэгэн сэтгэлт, үнэнч зүтгэлт, бие сэтгэлээрээ, солонго мэт сонсдог, үен мэт үздэг
 - үтэр цуглуулах, эхэд бараалхах, хорвоогоос халих, гэзгээ задлах, зүрх эмтрэх, хагацан одох, айлдах, түмэндээ сонордуулах, мэхэсхийн хүндэтгэх
 - гудгар, урвагар, тунгалаг, өтгөн буурал, цуулмал, цагаан, цөвүүн, солонго мэт, үен мэт, цонхигор, бөөр алаг
 - шөнө дунд, мичид шингэх мөч, тэр нэгэн цөвүүн өдөр, үүрийн харанхуй
13. “Эзэн дээдсийн төлөөнөө ёсч шударга, цэгц үнэн журмыг сахихын үлгэрийг үзүүлсэн энэ иргэнийг Хамаг Монголын хаад, ноёд, харц ард хэн боловч мартаж ёсгүй” гэсэн хэсэгт ямар өнгө аяс илэрч байна вэ?
- хөөрхийлсэн
 - тайтгарсан
 - цэцэрхсэн
 - сануулсан
 - санааширсан
14. “Гэвч... чи, Тэмүүжин хүүг минь баахан мартсан мэт” гэсэн өгүүлбэрт цуваа цэг хэрэглэсний учир юу вэ?
- Мэгдэж түгдэрсэн тул цуваа цэг хэрэглэсэн.
 - Үг, өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй дутуу орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
 - Өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэг хэрэглэсэн.
 - Эш татсан зүйлийн энд тэндээс орхисон тул цуваа цэг хэрэглэсэн.
 - Зохиолын том бүлэг, их хэсгийг орхисон тул мөрлөсөн цэг хэрэглэсэн.
15. Эсрэг утгатай үг бүхий хэлцийг сонгоорой.
- Бохирыг нь арилгаж, борвийг нь тэнийлгэх
 - Навч цэцэг нарнаас, насны жаргал ажлаас
 - Наадаж явбал насны жаргал, инээж явбал өдрийн жаргал
 - Данх руугаа толгойгоо хийсэн, тогоо руугаа хошуугаа хийсэн
 - Мандахдаа үүдээр багтахгүй, муудахдаа үүдээр гарахгүй
16. Дээд найруулгын зэрэг бүхий өгүүлбэрийн сонгоорой.
- Туурга нэвт туяатай, гэр нэвт гэгээтэй.
 - Нарт тэнгэрийн дор насад энх амьдарна.
 - Нарны гэрэл тооноор тусаж, гэрт гэгээ нэмнэ.
 - Мэргэд гэдэг бол нар сарыг хамтатгасан хурмаст гэвээс болно
 - Нар шиг мандаж, сар шиг гэрэлтэнэ.








17. “-ын, -ийн -ий,-ы” бүтээвэр нь зориулалтын утга ялгаж байгаа хэсгийг олоорой.
 А. нүдний шил, шүдний сойз
 В. газрын хол, усны урт
 С. уулын чулуу, усны эх
 D. сарын сайн нь, өдрийн сайхан нь
 E. миний ном, чиний цүнх
18. Ихэсгэж хэтрүүлсэн дүрслэл бүхий өгүүлбэрийг сонгоорой.
 А. Туг сайхан сүүлтэй, тугал хар нүдтэй...
 В. Туулай сайхан зоотой, дугариг сайхан хүзүүтэй...
 С. Ерэн алд биетэй, есөн төө чихтэй...
 D. Ан шувуундаа унадаг их хар морьтой...
 E. Хас эрдэнэ шүдтэй, халир мөнгөн уруултай...
19. “Баатар ах **анхандаа** миний хичээлийн хуваарийг ялгаж өгдөг байв” гэсэн өгүүлбэрийн онцолсон гишүүний утга, үүргийг зөв тодорхойлсон хэсгийг олоорой.
 А. “өгдөг байв” гэснийг орны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 В. “хуваарийг” гэснийг цагийн утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 С. “ялгаж өгдөг байв” гэснийг хугацааны утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
 D. “хичээл” гэснийг тодотгож, дэлгэрүүлэх үүрэгтэй.
 E. “Баатар ах” гэснийг шинж чанарын утгаар дэлгэрүүлэх үүрэгтэй.
20. Нийлмэл үгийн бүтсэн аргыг ажиглаад цэгийн оронд тохирохыг сонгоорой.
 Аз жаргал, төмөр зам, эрч хүч, туулайн бөөр,.....
 А. эрүү толгой
 В. ган зам
 С. модон байшин
 D. цэцгийн дэлбээ
 E. санааны чимэг
21. Төрөл биш үгийг олоорой.
 А. буурь
 В. буудай
 С. буудал
 D. буулт
 E. буулгалт
22. Үндсэн утгаараа байгаа холбоо үг аль нь вэ?
 А. морь алдах
 В. сэтгэл алдах
 С. нүд алдах
 D. шүүрс алдах
 E. ам алдах
23. Дүрслэх язгуур бүхий үгийг олоорой.
 А. пасхий
 В. хархий
 С. түсхий
 D. торхий
 E. гэдий
24. Эдгээр үгэнд бүтээвэр залгаж бичихэд гийгүүлэгч нэмэгдэх үгийг олоорой.
 А. орон+ы
 В. байшин+ийн
 С. дуусах+ын
 D. ээлж+ийн
 E. гадна+ы
25. Бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.
 А. дуусч, тосч, харуусч
 В. тарьчих, өгчхүүзэй, жимийлций
 С. саначхаад, буудаллаа, хэлбэл
 D. тогтчоод, саначихыг, мартчихангуут
 E. больчихыг, болччоод, ороочхонгуут
26. “**ᠠᠨᠠᠭᠠᠨᠠᠨᠠᠨ** ᠐ ᠪᠠᠭᠠᠨ” гэсэн холбоо үгийг зөв уншаарай.
 А. атаачны хүү
 В. адуучны гүү
 С. адуучны хүү
 D. атаачны хөө
 E. адуучны хөө
27. “тараг” гэсэн үгэнд үйлдэхийн тийн ялгалын нөхцөл дагуулсныг олоорой.
 А. 
 В. 
 С. 
 D. 
 E. 
 А. 
 В. 
 С. 
 D. 
 E. 





28. Зөөлөн дэвсгэрээр төгссөн хэсгийг сонгоорой.

- A.  B.  C.  D.  E. 




29. “-саар⁴” нөхцөл залгахад холбох эгшгийн дүрмээр бичигдэх үгс нь аль вэ?

- A.  B.  C.  D.  E. 

30. Уншаад холбох эгшгийн дүрмээр бичсэн үгийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 






31. Уншаад зөв харгалзуулсан хэсгийг олоорой.

1.  2.  3. 






- a.Австри
b.автономи
c.автоматч

- A. 1b,2 a,3c B. 1a,2 b,3c C. 1a,2c,3b D. 1c,2a,3 b E. 1b,2c,3a

32. “Гэв гэнэт хашгирав” өгүүлбэрийн онцолсон үгийг зөв бичсэнийг олоорой.

- A.  B.  C.  D.  E. 

33. “Тэр одоохондоо унаа аваагүй” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийг хэрхэн бичих вэ?

- A.  B.  C.  D.  E. 

34. “” гэсэн үгийн утгад тохирох холбоо үг аль нь вэ?

- A. хурга ишиг B. хороох цөөлөх C. ахмадын хороо
D. гар хуруу E. адуу хураа



35. Уншихдаа онцолсон үгийн бичлэгийг ажиглаад бүгдийг зөв бичсэн хэсгийг сонгоорой.

- | | | | | |
|--|--|--|--|--|
| A. | B. | C. | D. | E. |
| Өгср Өгсрө хгср мср нн
Лгхгхснрэн мсгггсгср гхгср гхгсгсрн
мхгггср гсгсгср хгср мср нн гхгсгср гср
мсгср г хн нсггсгсрлхгср гхгср гхгсгсрн .. | Өгср Өгсрө хгср мср нн
Лгхгхснрэн мсгггсгср гхгср гхгсгсрн
мхгггср гсгсгср хгср мср нн гхгсгср гср
мсгср г хн нсггсгсрлхгср гхгср гхгсгсрн .. | Өгср Өгсрө хгср мср нн
Лгхгхснрэн мсгггсгср гхгср гхгсгсрн
мхгггср гсгсгср хгср мср нн гхгсгср гср
мсгср г хн нсггсгсрлхгср гхгср гхгсгсрн .. | Өгср Өгсрө хгср мср нн
Лгхгхснрэн мсгггсгср гхгср гхгсгсрн
мхгггср гсгсгср хгср мср нн гхгсгср гср
мсгср г хн нсггсгсрлхгср гхгср гхгсгсрн .. | Өгср Өгсрө хгср мср нн
Лгхгхснрэн мсгггсгср гхгср гхгсгсрн
мхгггср гсгсгср хгср мср нн гхгсгср гср
мсгср г хн нсггсгсрлхгср гхгср гхгсгсрн .. |

ХОЁР ДУГААР ХЭСЭГ. ХАРГАЛЗУУЛАХ ДААЛГАВАР

Санамж:

- Энэ хэсэг сонгох даалгавар биш тул харгалзааг зөв тогтоож, хариуг будаарай.
- Зөв харгалзуулсан хариулт бүр нэг оноотой.

2.1. Хэлцийг утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|---------------------------------|--------------------|
| a. Өрөмний өт шиг | 1. ихэд санаархах |
| b. Бой нь арилж борви нь тэнийх | 2. хоосон мөрөөдөх |
| c. Дотор нь ороод гарсан юм шиг | 3. сайн мэдэх |
| d. Зангуу тариад эсгий хийх | 4. тогтворгүй |
| e. Оготнын дуу тэнгэрт хүрэхгүй | 5. том болох |

2.2. “Монголын нууц товчоо” зохиолын эшлэлийг хам сэдэвтэй зөв харгалзуулаарай.

- | | |
|--|------------------------------|
| a. Барс жил /1206/ Онон мөрний эхэнд хуралдаж, есөн хөлт цагаан тугаа мандуулаад, Тэмүүжинд Чингис хаан /Далай хаан/ цолыг өгөв. | 1. Шашин шүтлэгийн хам сэдэв |
| b. Мэргидийн нутаг дээр булган малгайтай, бугын арьсан гуталтай, булган хөөмий дээлтэй Хүчү гэдэг нэртэй, таван настай хөвүүн хоцорсныг олов. | 2. Соёлын хам сэдэв |
| c. Тэр цагт Чингис хаан, тэнгэр эцэгтээ мөргөө гэж довцог өндөр дээр гарч, тохмоо дэлгэж тавиад, бүсээ хүзүүндээ өлгөж залбиран өчив. | 3. Түүхийн хам сэдэв |
| d. Улсыг байгуулахад зүтгэсэн хүмүүсийг түмний ноёд, мянганы ноёд, зууны ноёд, аравны ноёд болгож, соёрхлыг өгөх хүмүүст өгч зарлиг буулгав. | 4. Нийгмийн /ахуй/ хам сэдэв |
| e. “Алаг сайхан хоньдыг ар дүүрэн бэлчээж, хонин олон сүргийг хот дүүрэн өсгөж, шимтэй шөлийг бэлтгэж явъя” гэсэн тул Дэгэйгээр хонь адуулгав. | 5. Улс төрийн хам сэдэв |



2.3. Зөвийг нь олж сонгоорой.

		1.	2.	3.
a	Эцсийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэх үг	баялаг+ийг	хүчтэн+ээс	туулчих+аар
b	“я”-г шууд залгаж бичих үг	уралд+я	хамгаал+я	уя+я
c	Зөөлний тэмдэг “и” болохгүй үг	тарь+мал	шаагь+ж	тахь+саар
d	Эр үгэнд “ий” бичих үг	жудаг	дамжлага	ангир
e	“-л” залгавар залгахад хойноо эгшигтэй бичих үг	данс	харш	жүжиг

2.4. Дүрс ялган бичих үгсийг тохирох утгатай нь харгалзуулаарай.

- | | |
|-------------------|--------------|
| a. ᠶᠢᠨᠪᠢ | 1. очно гэв |
| b. ᠶᠢᠨᠪᠢ | 2. гэв гэнэт |
| c. ᠶᠢᠨᠪᠢ | 3. ид хав |
| d. ᠶᠢᠨᠪᠢ | 4. дээл хав |
| e. ᠶᠢᠨᠪᠢ | 5. хав хатуу |

СОНСОХ ДААЛГАВАР

Гүйцэтгэх хугацаа: 15 минут [10 оноо]

Санамж:

- **Эхийг анхааралтай сонсоод асуултад хариулаарай.**
- **Хариултын хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудасны /36-40/ зааврын дагуу будаарай. Хариулт бүр 2 оноотой.**

36. “би” баатрын балчирхан бага насны мөрөөдлүүдээс “гар нь ганзаганд, хөл нь дөрөөнд хүрэх” гэсэн хэлцтэй дүйх утгатайг нь сонгоорой.
- A. Чихэр жимс, бал бурмыг авчирч, айл саахалтынхандаа түгээх
 B. Хурдхан шиг өсөж, тэнгийн булан даахуйц эр болох
 C. Цэнхэр уулсын чанадад хот гэж нэг ариун дагшин оронд очих
 D. Үдэш шандан дээр очиж, морио услаад, онгоцоо усаар дүүргэх
 E. Нутаг дээрээ өрөөстэй нь орхисон чулуун тоглоомоор тоглох
37. Нүүдэлчдийн ахуй амьдралыг аль өгүүлбэрт дүрсэлсэн байна вэ?
- A. Хаврын их нүүдэл аараг борхон толгодын шилээр дэнхэн данхан давна.
 B. Тэр үед хот ороод буцаж ирэхийн тухайд санаж явснаас биш шингэн гэж бодоогүй.
 C. Зарим нь арав хорин жил зэргэлдээ аж төрсөн хэрнээ бие биенээ таньдаггүй.
 D. Дөчин насны дөрөөнд гишгэсэн ч өөрийгөө хөдөөгийн хүүхэд гэж бодож явдаг
 E. Би он цагийн урсгалд хөдөөгийн ааш араншингаа сэвтүүлэхээс эмээдэг.
38. “би” баатар нь хотынхон хөдөө нутгаараа бахархахгүй байгаагийн гол учрыг юу гэж дүгнэсэн бэ?
- A. Чөлөөтэй нэг сайхан эргэцүүлэн бодох завгүй тул
 B. Ном эрдэмд сэтгэлээ зориулсан юм үзэж, нүд тайлсан тул
 C. Нүдээ гөлөртөл цангасан малд ганц ховоо ус хийж өгч үзээгүй тул
 D. Гоёж гооддог шигээ өнгө хуурамчхан зантай, атаа жөтөөч хүмүүс тул
 E. Арав хорин жил нэг байшинд аж төрсөн хэрнээ бие биенээ таньдаггүй тул
39. Хөдөөгийн хүүхдийн араншинд *хамаарахгүйг* нь сонгоорой.
- A. Эрт ухаажиж, чулуу таалцахын оронд чөдөр зангидаж сурсан.
 B. Өртөг өнгө хоёр шингэсэн оньсон тоглоомоор тоглож өссөн.
 C. Үг яриа нь хүртэл төвшин, сонсголонтой, элдэв гоёл чимэггүй.
 D. “Мал ирж юу магад уу” гэж бодоод, онгоцоо усаар дүүргэж орхидог.
 E. Боргоцой бяцхан гартаа харандаа барьж, дэнгийн гэрэлд үсэг холбож суусан
40. “Өөрөөсөө байн байн эрж, өврөө тэмтэрч үзээд байдаг” зүйл нь юу вэ?
- A. Чулуун тоглоом
 B. Чихэр жимс, бал бурам
 C. Өнчин ишиг
 D. Хэлхсэн бодол
 E. Хөдөөгийн араншин

